

Миний багийн найзыг Сэрдамба гэдэг. Бид хоёр бүр цэцэрлэгт нэг ангид байлаа шүү дээ. Би найзынхаа хөдөлмөрч, шудрага, үнэнч зангаар бахархдаг. Найз минь одоо алдартай тамирчин болсон төдийгүй “Ирвэс” багийн дасгалжуулагчаар ажиллаж байна.

Ташаарсан нь	Залруулсан нь

Уран зохиол

7. Д. Нацагдорж “Ламбугайн нулимс” зохиолос нэг дүр сонгон, тухайн дүрийн хийсэн үйлдэл, хэлсэн үгээр нь зан төрхийг дүгнэн бичээрэй. Бичихдээ зохиолоос жишээ авч батлаарай. Үгийн тоо 40-50 [5 оноо]

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

8. Дараах шүлгийг уншаад эгшиглэл, бадаглал, холбоц, мөрийн тоог тэмдэглээрэй. [2 оноо]

Эелдэг урьхан амьсгал ариухнаар үнэртээд
 Эрт эдүгээг бодогдуулан нуугдсан сэтгэлийг сэргээнэ
 Өнөр сайхан төл баян хотыг чимэхэд
 Өлгийтэй бяцхан хүүхэд эцэг эхээ баясгана.

.....

.....

.....

9. Жүжгийн зохиолын хэл яриа гэж юу вэ? “Саран хөхөөний намтар” жүжгийн хэсгээр батлаарай. [2 оноо]


.....

.....

.....

Үндэсний бичиг

10. Дараах эхийг уншаад кирилл бичигт хөрвүүлээрэй. [5 оноо]



БАТЛАВ

ЗАХИРАЛ

В.АЛТАНСУВД

10-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

2024 оны 5-р сарын 31

Анги бүлэг

Хугацаа: 80 минут

Нэр:

Нийт 40 оноо

Монгол хэл:

Б вариант

1. “Спортоор хичээллэхийн ач тус” сэдвээр тайлбарласан эсээ бичээрэй. Үгийн тоо 180-200 [10 оноо]
2. Дараах нийлмэл өгүүлбэр хэдэн энгийн өгүүлбэрээс бүтсэн болохыг задлан бичээд, холбох аргыг тодорхойлоорой. [4 оноо]

Өгүүлбэр нь: Эргүүлгийн ухаан улам задарч бууны гол төмөрт шилжсэн тэр л үеэс хүний нийгэмд гаслан тарьсан зэвсэг их хүчтэй болж, сумны хурд эрс нэмэгджээ.

.....
.....
.....
.....

3. “Урт гартай” хэлцийн утгыг тайлбарлаж бичээрэй. Тус хэлцийг өгүүлбэрт оруулан, нийлмэл өгүүлбэр бүтээгээрэй.[4 оноо]

Тайлбар нь:

Өгүүлбэрт оруулсан нь:

.....
.....
.....

4. Дараах өгүүлбэрүүдийн онцолсон үгсийн нөхцөлийг утга тохирох бүтээврийг олж сонгоод, солин найруулж бичээрэй. [4 оноо]

➤ Бөөдэй үсрэн бууж олмоо тавиад, эмээлээ өргөж, мориныхоо нурууг нар харвахаас болгоомжлон салхи оруулж хэсэг сүүдэрлэн зогссоноо хазаараа мулталж инээсээр ирнэ..

-вал -нгаа -хлаар -снаа -н

Солин найруулсан нь:

.....
.....

➤ Хааяа унаагаа юүлүүлэх гэж адуугаа тууж ирэхэд нь би уургынхаа хээрийг барьж мордоод хорь хүрэхгүй адууг нь хураана.

-снээ -нгээ -хлээр -н -вэл

Солин найруулсан нь:

.....
.....

5. Дараах дүрэмд тохирох жишээ хоёрыг бичээрэй. [2 оноо]

Ялгах үүрэгтэй тул балархай эгшгийг гээхгүй. Жишээ нь: үнэн + ээс

.....

6. Дараах эхийн хэсгийг уншаад зөв бичих дүрмийн алдаатай 2 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай 1 үгийг олвол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо. [2 оноо]

